3. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 34,033.7 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд: төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 8,779.0 мянга, Сүмбэр сумын 2 дугаар сургуулиас шилжүүлж авсан барилга 65,041.2 мянга, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 2,695.0 мянга, үнэ шинэчлэн тогтоож дахин үнэлсэн 4 нэр төрлийн хөрөнгө 1,770.0 мянга, тооллогоор бүртгэлд авсан 5,000.0 мянга, нийт 83,285.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. АИТХ-ын тэргүүлэгчдийн 2022 оны 05 дугаар тогтоолоор 16,095.7 мянган төгрөгийн худгийг Ус-Ду ОНӨААТҮГ-т шилжүүлж, АИТХ-ын 2022 оны 135 дугаар захирамжаар 17 нэр төрлийн 15,419.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.
4. Засгийн газрын хувь оролцоо данс өмнөх оноос 29,089.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 952,988.4 мянган төгрөгийн санхүүжилт, зарлагыг 952,988.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орлого, зардлыг 166,528.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, оны эхэнд 1,119,517.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 22,442.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж жилийн эцэст 1,141,959.7 мянган төгрөг болгож тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэхээр 316,072.4 мянга, 80103 арга хэмжээг санхүүжүүлэхээр 178,060.6 мянга, 80106 арга хэмжээг санхүүжүүлэхээр 122,760.1 мянга, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 76,458.9 мянга, 80205 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,575.8 мянга, 80305 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,000.0 мянга, 80802 арга хэмжээг санхүүжүүлэхээр 27,168.1 мянга, 81102 арга хэмжээг санхүүжүүлэхээр 25,000.0 мянга, 82203 арга хэмжээг санхүүжүүлэхээр 61,734.0 мянга 82212 арга хэмжээг санхүүжүүлэхээр 332,129.8 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,141,959.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,085,277.0 мянган төгрөг буюу 95 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 9,318.4 мянга, гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ 42,546.3

мянга, баг хорооны үйл ажиллагааны зардал 943.1 мянга, нийтлэг үйлчилгээ 1,461.8 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 160.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101	316,072.4	306,754.0	9,318.4	97.1
2	70106-80103	178,060.6	135,514.3	42,546.3	76.1
3	70106-80106	122,760.1	121,817.0	943.1	99.2
4	70106-80112	76,458.9	74,997.1	1,461.8	98.1
5	70106-80205	1,575.8	1,570.0	5.8	99.6
6	70106-80305	1,000.0	996.8	3.2	99.7
7	70106-80802	27,168.1	27,007.6	160.5	99.4
8	70106-81102	25,000.0	22,756.5	2,243.5	91.0
9	70106-82203	61,734.0	61,734.0	0.0	100.0
10	70106-82212	332,129.8	332,129.8	0.0	100.0
	Нийт	1,141,959.7	1,085,277.0	56,682.7	95.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ГХУС хамтарсан багийн үйл ажиллагааны орлого 300.0 мянга, тендерийн орлого 1,015.0 мянга, нийт 1,315.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бичиг хэргийн зардалд 1,071.0 мянга, зарын төлбөрт 144.0 мянга, шатахууны зардалд 100.0 мянга, нийт 1,315.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материал, шатахууны тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/66 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүн 1,121,142.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,211.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэр мэдээлээгүй, нийт 18,977.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.2.11 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тулган баталгаажуулалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүйгээс 9,701.5 мянган төгрөгийн зөрчил /илүү 3,954.1 мянга, дутуу 5,747.4 мянга/ үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягт зааврын НХМаягт ТМ-5 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний 3-р улирлын байдлаар хийсэн завсарын аудитаар өгсөн 12,214.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	668.5	1	668.5	100
Албан шаардлага	2	64,063.9	2	51,251.1	80
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	3	64,732.4	3	51,919.5	90

Өмнөх аудитаар 64,732.4 мянган төгрөгийн 3 зөрчил илрүүлж, 64,063.9 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 668.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт,

зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.7 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" стандартыг баримтлаагүй, ангилал батламж мэдэгдлийг хангаагүй

Аудитаар нийт 466.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 466.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

5.1. Төлбөрийн акт

5.1.1. Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан 4 албан хаагчид нийт 466.7 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтууд, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Албан шаардлага өгөөгүй

5.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд тухайн байгууллагын автомашин нь ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг бичээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4" дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсанд ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг тодорхой бичих, хэдэн км зарцуулснаа хянаад гарын үсэг зурах, нягтлан бодогч тооцоог хийж шатахууны хэтрэлт хэмнэлтийг гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/минган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Завламж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Завламж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө худалдан авсан зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй	1	8,779.0	1	8,779.0			1	8,779.0		
Даатгуулагчаас төлөх НДШ-ийг ажил олгогчоос төлсөн	1	3,347.2			1	3,347.2	1	3,347.2		
Томилолын зардлыг олгохдоо 16 хүнд хоолны зардал давхардуулан олгосон	1	88.0			1	88.0	1	88.0		
Саяхилын шийтгэл ногдуулсан ажилтны суутгалиг үр дүнгийн тайланд орлогоор бүртгээгүй	1	137.3	1	137.3			1	137.3		
Цэвэр бохир усны зардалд өр төлбөртэй гарсан боловч өөр байгууллагаар төлүүлэн өр төлбөрөө хаялгасан, өр төлбөрөө санхүүгийн тайланд тусгаагүй	1	3,282.7	1	3,282.7			1	3,282.7		
Ахмадын сангийн орлогыг орлого үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн	1	10,930.4			1	10,930.4	1	10,930.4		
Татварын тайланд 3 хүний цалинг илүү тайлагнасан	1	5,854.9			1	5,854.9	1	5,854.9		
Дүн	7	32,419.5	3	12,199.0	4	20,220.5	7	32,419.5		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эзлэгийн амралтын олгоогыг цалин хөлстэй давхардуулан 4 албан хаагчид нийт 466.7 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон	1	466.7	1	466.7				
Жолоочийн тооцроны хуудсанд тухайн байгууллагын автомашин нь ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг бичээгүй	1	-			1	-		
Нийт	2	466.7	1	466.7	1	-		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэр, цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 4 зарлагын гүйлгээ, 1 орлогын гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан тус тус мэдээлээгүй	1	18,977.0			1	18,977.0
Дүн	1	18,977.0			1	18,977.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүйгээс зөрүү үүссэн	1	9,701.5			1	9,701.5
Дүн	1	9,701.5			1	9,701.5
Нийт дүн	2	28,678.5			2	28,678.5



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар

62/АБС/082
ГА-2023/05/14-ЦА-ТУС

Чайр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн хийсэн "Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар"-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 18,977.0 мянган төгрөгийн 6 тушаал шийдвэр мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 7 дугаар зүйлийн 7.1.1-т "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журал"-ын 2 дугаар зүйлийн 2.2.3.2-т зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 3.2.11-т "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хэвсгэлтэд заасан маягтын дагуу PDF форматаар" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журал"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг бүрэн арилгах, мэдээллийг нөхөн мэдээлж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹ ирүүлэх;

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

079040087

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүмбэр сумын Засаг даргын тамгын дарга П.Наранмандах, нягтлан бодогч Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР *Анхтуяа* Б.АНХТУЯА
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Болор-Эрдэнэ* Б.САРАНТУЯА





ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 25/А096/082
ГЭА-2023/05/НА-ОА-ТУС

Чөйр

Зөрчил өрилгэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн хийсэн "Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар"-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шлвэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5-д "төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

048040091

1. Цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг арилган биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүмбэр сумын Засаг даргын тамгын дарга П.Наранмандах, нягтлан бодогч Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР		Б.АНХТУЯА
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.САРАНТУЯА

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 10/А0861082
ТГА-0023/05/НА-СТА-ТЧЗ

Чөлрө

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар"-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан 4 хүнд 466.7 мянган төгрөг илүү тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Ажилтны ээлжийн амралт, ээлжийн амралтын цалинг ажил олгогч тооцож олгоходоо Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 99, 110 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална", 3 дугаар зүйлийн 3.1-т "Ажилтны ээлжийн амралтын цалинг ээлжийн амралт эдлэхээс өмнө олгоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-т "Цалин хөлс, шаанал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан илүү тооцож олгосон нийт 466,670.00 төгрөгийг удирдлага, санхүүгийн ажилтан нар хариуцан барагдуулж,

0800060003

Төрийн сан дахь орон нутгийн орлогын "Төсөвт байгууллагын өөрийн орлого"
100220000954 тоот дансанд төвлөрүүлэх

2. Актын биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын
дарга П.Наранмандах, нягтлан бодогч Б.Болор-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР		Б.АНХТУЯА
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.САРАНТУЯА

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179